Үйл ажиллагаа 3. ЗНӨ бүтээдэг холбох үгсийг судалж, илэрхийлэх утгыг задлан шинжлэх
Алхам 2. Дараах зэрэгцүүлэн холбох үгс нь өгүүлбэрт ямар утгаар орж байгааг жишээн дээр тулгуурлан харгалзуулаарай. (5 минут)

№	Өгүүлбэр
1	Лам өдөр бүр хэдэн аяга хар цай, боовны хугархай өгөх **ба** хүү оройд нь ганц хоёр аяга хоол иднэ.
2	Түүхий ус уусан **хийгээд** сувилгаа муудсан.
3	Ханд ноцоон ядах **бөгөөд** түүний утаа нь гэрийн дотор бүгшин, нүд хорсгоно.
4	Хүний сайхан нь дотроо гэрэлтэх **агаад** сайн хүн гэдэг нь ариун сэтгэлээсээ харагддаг
5	Хүн ажлыг залуудаа чадлаараа хийдэг, **харин** насжаад ирэхлээр ухаанаараа хийдэг.
6	Тэр гал нээх тушаал өгөв үү **эсвэл** хасгууд өөрсөө дураараа загнав уу
7	Миний ууц нуруу бадайрдаг **бол** Лувсангийн ууц нуруу шархирдаг гэнэ.

Утга
A. Орон, цаг, учир зүйн холбогдолгүй хоёр үгийг зэрэгцүүлэн тавьж, тоочсон.
B. Хоёр үгийг зэрэгцүүлэн тоочсон.
C. Урьдчилан, эсвэл зэрэгцсэн хам олны утга илэрхийлж байна.
D. Эсрэгцлийн утгатай, нэгийг үгүйсгээд нөгөөг нотолсон утгатай.
E. Лавшруулах утгаар зэрэгцүүлсэн.
F. Эс сонгох, болзол тавих утга илэрхийлсэн
G. Эсрэгцүүлэн жиших утга санаатай.

LIVEWORKSHEETS